

## МОНГОЛ-ВЬЕТНАМ ХОЁР УЛСЫН ХАРИЛЦАА ӨНГӨРСӨН 50 ЖИЛД

*С.Дашцэвэл\**

Монгол, Вьетнам хоёр улсын харилцаа их эртний уламжлалтай. Энэ харилцаа наад зах нь 700 гаруй жилийн түүхтэй. Үүнийг үл өгүүлэн сүүлийн 50 жилийн харилцааны тоймыг уншигч танаа толилуулъя..

1954.11.17-нд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон явдал бол тухайн үеийн олон улсын харилцааны түүхэн нөхцөл, Монгол, Вьетнам хоёр улсын дотоод гадаад бодлогын үндсэн зорилт, хоёр талын хүчин чармайлтын үр дүн байлаа.

Монгол, Вьетнам хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон явдал хоёр улсын эрх ашиг, хүсэл сонирхолд нийцсэн, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх таатай боломжийг нээсэн чухал ач холбогдолтой үйл явдал болж хоёр орны харилцааны түүхэнд цоо шинэ үеийг нээсэн.

Дипломат харилцаа тогтоосноос хойшхи 50 жилийн түүх бол хоёр улсын харилцааны хамгийн онцгой, түүхэн үе гэж хэлж болно.

Дипломат харилцаа тогтоосноос хойшхи хоёр орны харилцааны 50 жилийн түүхийг дэлхий дахины болон тухайн хоёр орны улс төр, нийгмийн хөгжлийн өөрчлөлт, хувьсалтай уялдуулан авч үзвэл хэд хэдэн өвөрмөц үеийг дамжин хөгжиж ирсэн байна. Үүнд:

1. Дипломат харилцаа тогтоосон эхэн үеийн харилцаа /1954-1965 он/
2. Энэтхэг-Хятадын хойг дахь дайны үеийн харилцаа /1965-1975 он/
3. Дайны дараах үеийн харилцаа /1975-1980-аад оны сүүлч/
4. 1990-ээд оноос эхэлсэн шинэ үеийн харилцаа гэсэн хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж ирсэн байна.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон эхэн үеийн харилцааны тухай товчхон танилцуулъя. Энэ үе бол 1954-1965 оны хоорондох үе юм.

1950-иад оны эхэн үе бол хүйтэн дайны шинж чанар дэлхийн бодлогод улам гүнзгий тусаж байсан цаг үе. Монгол улс тэр үед социалист лагерийн ууган орон байсан бөгөөд дотоод бодлогодоо социалист үйлдвэрлэлийн харилцааг бий болгохын төлөө тэмцэж, социалист бүтээн байгуулалтын эхлэлийг тууштай тавьж байсан үе. Тэр үед Монгол Улс дэлхийн социалист орнуудтай бүх талын харилцааг хөгжүүлж, тэдний дэмжлэг тусалцааг авах, социалист лагерийн эв нэгдлийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байсан.

\*С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Вьетнамын ард түмний хувьд Зүүн өмнөд Азид, бүр тодруулбал Энэтхэг-Хятадын хойгт анхны ардын ардчилсан тогтолцоо бүхий улс орныг 1945 онд бий болгож Францын интервенцийн эсрэг 9 жил үргэлжилсэн дайныг Женевийн бага хурлын дүнд дөнгөж зогсоогоод байсан үе. Энэ үеийн БНАВУ-ын гол зорилт бол дайнд туйлдсан улс орныг сэргээн босгох 1954 оны Женевийн бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлж улс үндэстнээ нэгтгэх, үүний тул дэлхийн социалист системийн орнуудтай бүх талын харилцааг хөгжүүлж, дэлхийн олон нийтийн дэмжлэгийг аль болохоор авах явдал байсан юм.

Түүхэн энэ нөхцөлд үзэл, зорилго нэгтэй Монгол, Вьетнам хоёр улс дипломат харилцаа тогтоож, улс төр, эдийн засаг, соёлын г.м. нийгмийн амьдралын бүх салбарт харилцааг хөгжүүлж эхэлсэн юм. Тухайлбал улс төрийн салбарт:

1955 онд Ерөнхийлөгч Хо Ши Мин тэргүүтэй БНСВУ-ын төлөөлөгчид Монголд, 1959 онд МАХН-ын ТХ-ны 1-р нарийн бичгийн дарга, СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын нам засгийн төлөөлөгчид Вьетнамд, 1961 онд Вьетнамын Хөдөлмөрчдийн намын төв хорооны УТТ-ны гишүүн, БНАВУ-ын Засгийн газрын ерөнхий сайд Фам Ван Донг тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид Монголд тус тус айлчлав.

Энэхүү анхны айлчлалууд Монгол, Вьетнам хоёр улс бие биенээ танин мэдэх, улс төр, эдийн засгийн салбарт бие биенээ дэмжин туслах явдалд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Тухайн үед хэд хэдэн чухал гэрээ хэлэлцээр байгуулсаны дотроос 1961 онд гарын үсэг зурсан Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ нь тэр үеийн социалист гэгдэж байсан орнуудын харилцааны дээд төвшинг илэрхийлсэн, цаашдын харилцааны үндсэн зарчим, чиг шугамыг тодорхойлсон түүхэн чухал баримт бичиг байлаа.

Энэ үед Монгол улс НҮБ-д албан ёсны байр сууриа эзлэх эрхийг БНАВУ бүрэн дэмжиж байв. Монгол улсын хувьд Женевийн бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, БНАВУ-ын бодлого, байр суурийг тууштай дэмжиж байлаа.

1957 онд хоёр улсын хооронд харилцан бараа солилцох төлбөр тооцоо хийх журмын тухай хэлэлцээр байгуулж хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа албан ёсоор эхлэсэн түүхтэй.

1957-1960 онд хоёр улсын худалдаа эргэлт 1,3 сая рубль байсан бол 1961-1965 онд 5,8 сая рубль болжээ. Энэ үед Монголоос Вьетнамд арьс шир, гуллын дотор илэг, бугын эвэр, хонины угаасан ноос, ээрмэлийн утас, савхи зэрэг барааг нийлүүлж байв. Вьетнамаас газрын самар, хатаасан банан, торго, гар нэхмэлийн зүйл, хүүхдийн хувцас зэргийг нийлүүлж байлаа.

Олон жилийн дайнд нэрвэгдсэн Вьетнамын эдийн засаг энэ үед туйлын хүнд байсан учраас ах дүү социалист орнууд түүний дотор Монгол улс 50-иад оны дунд үеэс эхлэн Вьетнамын ард түмэнд эд материалын тусламж үзүүлж эхэлсэн юм. Тухайлбал 1955 онд ерөнхийлөгч Хо Ши Миныйг Монголд айлчлах үеэр 106 үхэр, 520 ямаа бэлэглэв. Энэ бол Монгол улсаас Вьетнамын ард түмэнд илгээсэн анхны тусламж байв.

Дараа нь 1959 оны 8-р сард БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал Вьетнам улсад айлчлах үедээ 100,000 толгой мал бэлэглэхээр амалсан бөгөөд түүнээс 798 толгой малыг 1959 оны 12-р сард Вьетнамд хүргүүлсэн.<sup>1</sup>

Монгол улсаас Вьетнамд МАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр ийнхүү чин сэтгэлийн тусламж үзүүлсэн явдал Вьетнамын ард түмэнтэй ах дүүгийн барилдлагыг улам бататган гүнзгийрүүлсэн юм. Энэ үед Вьетнамын ерөнхийлөгч Хо Ши Мин: “Бидэнд ах дүү Монгол нөхөд тусламжийн халуун гараа сунгаж, чин сэтгэлийн асар их тусламж үзүүлж байна. Монгол улс манай улсаас юу л хэрэгтэй байна, түүнийгээ нэрэлхэлгүйгээр хэлээд аваарай. Бид хамтдаа хөгжиж дэвших учраас манай эд баялаг бол танайх л гэсэн үг. Хэрвээ нутаг орондоо хэрэгтэй гэвэл манай одос үхрээс авч өсгөж туршаарай” гэж хэлж байжээ.<sup>2</sup>

Энэ үед соёлын харилцаа үүсч хөгжих эх сууриа тавьсан. Тухайлбал 1958 онд Соёлын талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж урлаг соёлынхон харилцан айлчилж эхэлсэн.

1958 онд Монголын Ардын дуу бүжгийн чуулганы бүжигчид Вьетнамд /Вьетнамын Хөдөлмөрийн 1-р зэргийн одонгоор шагнуулсан/, 1962 онд Вьетнамын Ханой хотын Дуу бүжгийн чуулгын жүжигчид Монголд тус тус айлчилан тоглосон. /Алтан гадас одонгоор шагнав/

Мөн боловсролын салбарт харилцаа үүсч оюутан солилцож сургах ажлыг эхлүүлсэн байна.

Энэхүү харилцааны эхэн үе /1954 -1965 он/ бол үзэл зорилго нэгтэй Монгол, Вьетнам хоёр улс дипломат харилцаа байгуулж социалист гэгдэх нэгэн гэр бүлд эв нэгдлийг эрхэмлэн улс төр, эдийн засаг, соёл боловсрол зэрэг бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагааны эх суурийг баттай тавьж чадсан зурвас үе гэж хэлж болно.

1960-аад оны дунд үеэс эхлэн Энэтхэг-Хятадын хойгт дайн өргөжиж, тус бүс нутаг дэлхийн хамгийн халуун цэг болж хувирсан. Энд нэг талаас АНУ тэргүүтэй империалист хүчин, нөгөө талаас ЗСБНХУ тэргүүтэй коммунист ертөнцийн ашиг сонирхол халз мөргөлдөж байв.

Энэ үед социалист нөхөрлөлийн орнууд Вьетнамыг дэмжих бодлого үйл ажиллагаагаа нягт уялдуулан зохицуулж байв.

Монгол улс социалист нөхөрлөлийн гишүүн орны хувьд ах дүү социалист Вьетнамын талд бат зогсож, БНСВУ-тай улс төр, эдийн засаг, соёлын харилцааг өргөжүүлэхийн зэрэгцээ эх орноо авран хамгаалахын төлөө тэмцэж байсан Вьетнам ах дүү нарыг хир чадлын хирээр дэмжин туслах бодлогыг хэрэгжүүлж байв.

Энэ үед манай хоёр орны харилцаа улс төрийн салбарт нэн идэвхитэй өрнөж байлаа.

### **Өндөр дээд хэмжээний айлчлал /1965-1975 он/**

- 1966 он БНСВУ-ын Засгийн газрын ерөнхий сайд Монголд айлчлав.
- 1967 он БНМАУ-ын нам засгийн төлөөлөгчид Вьетнамд айлчлав.
- 1969 он Өмнөд Вьетнамын Үндэсний чөлөөлөх фронт, Өмнөд Вьетнамын хувьсгалт төр засгийн төлөөлөгчид Монголд айлчлав.
- 1973 он Өмнөд Вьетнамын Үндэсний чөлөөлөх фронт, Өмнөд Вьетнамын хувьсгалт түр засгийн газрын төлөөлөгчид мөн айлчлав.
- 1973 он БНАВУ-ын нам засгийн төлөөлөгчид Монголд айлчлав.
- 1973 он Өмнөд Вьетнамын Үндэсний чөлөөлөх фронт, Өмнөд Вьетнамын хувьсгалт түр засгийн газрын төлөөлөгчид Монголд айлчлав.

Тухайлбал дайны эхний жилүүдэд /1966, 1967 онд/ хоёр улсын Нам Засгийн төлөөлөгчид харилцан айлчлав.

Энэ үеийн айлчлалын гол агуулга нь олон улсын байдлын талаар байр сууриа харилцан илэрхийлж, дайны нөхцөлд хоёр улсын харилцааг өргөжүүлэх, тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байв.

1969 онд Өмнөд Вьетнамын чөлөөлөгдсөн районд Хувьсгалт Түр Засгийн газар байгуулагдаж манай улс тэр Засгийн газрыг мөн онд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ үеэс эхлэн Монгол улс Умард Вьетнам төдийгүй Өмнөд Вьетнамын Үндэсний чөлөөлөх фронт, Өмнөд Вьетнамын Хувьсгалт Түр Засгийн газартай харилцаж эхэлсэн юм. Дайны үед Өмнөд Вьетнамын Түр Засгийн Газрын төлөөлөгчид хэд хэдэн удаа манайд айлчилж Өмнөд Вьетнамын улс төрийн байдал болон өөрийн бодлогыг танилцуулж байсан бөгөөд хоёр тал улс төрийн салбарт нягт харилцаатай байлаа.

Энэ үед манай Засгийн газраас “Вьетнамын ард түмэн өөрсдийнхөө хувь заяаг гаднын ямар ч оролцоогүйгээр шийдвэрлэх ёстой” гэсэн байр суурь баримталж байлаа. Энэ бол 1954 оны Женевийн бага хурлын гол үзэл санаа байсан юм.

1970-аад оны эхээр Вьетнамын асуудлыг энхийн замаар шийдвэрлэхийн төлөө Парисын хэлэлцээр явагдаж үүнтэй зэрэгцэн АНУ, Хятадын түншлэл хүчтэй болсон явдал ах дүү социалист нөхөрлөлийн орнууд, түүний коммунист намуудын нэгдсэн бодлого үйл ажиллагааг улам идэвхжүүлж Вьетнамын ард түмний тэмцлийг улам эрчимтэй дэмжихэд хүргэв. Энэ үед Монгол улсын Засгийн газар, монголын нийт ард түмэн ах дүү Вьетнамын ард түмний тэмцлийг тууштай дэмжиж өөрийн байр суурийг тухай бүр илэрхийлж байв.

Дайны үед Монгол улс, Вьетнам улсад үзүүлэх тусламжаа үлэмжхэн хэмжээгээр нэмэгдүүлсэн. 1965 оны 5-р сараас эхлэн Улс төрийн товчооны тогтоолоор улс орон даяар 2-3 өдрийн, 3-5 өдрийн цалингаар туслах өргөн хөдөлгөөн өрнүүлсэн. 1975 оныг хүртэл ийм хөдөлгөөнийг жил бүр өрнүүлж байлаа.

1966 онд Вьетнамыг дэмжих Монголын хороо, 1970-аад онд Энэтхэг-Хятадын хойгийн ард түмнийг дэмжих Монголын хороо байгуулагдсан явдал Вьетнамд үзүүлэх тусламж дэмжлэгийг сайн дурын үндсэн дээр өрнүүлэх, тусламжийг цуглуулах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулахад чухал арга хэмжээ болсон юм. 1969 оноос эхлэн зарим жил 2-3 удаа ийм хөдөлгөөнийг өрнүүлж байлаа.

Үүнээс гадна 1964-1975 онд өөрөөр хэлбэл зөвхөн дайны жилүүдэд Засгийн газрын будалтгүй тусламжаар 28 цуваа эд материал, хүнсний болон эмийн зүйл илгээсэн байна.<sup>3</sup> “Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны товч түүх” /УБ, 2000/ номонд дурьдсанаар 1956-1985 онд зөвхөн Засгийн газрын шугамаар Вьетнамд 200,0 гаруй сая төгрөгийн будалтгүй тусламж үзүүлсэн гэж тэмдэглэжээ.<sup>4</sup>

Дайны үеийн худалдаа эргэлтийн хэмжээ 1965-1970 онд 5,7 сая рубль<sup>5</sup>, 1970-1975 онд 4,2 сая рубль<sup>6</sup> тус тус болсон байна.

60-аад оны дундуур шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах Вьетнам, Монголын засгийн газар хоорондын комисс байгуулагдаж шинжлэх ухаан техникийн салбар дахь ололт туршлага солилцох, үндэсний боловсон хүчин бэлтгэх, мэргэжилтэн солилцох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байв. Энэ үеэс эхлэн Вьетнамаас жил бүр 5 оюутныг Монголын тал хүлээн авч их, дээд сургуульд сургах болов.

Энэ онуудад зохиолч сэтгүүлчид, уран бүтээлийн болон олон нийтийн байгууллагын олон төлөөлөгчид солилцсон байна. Мөн энэ үед Вьетнамын уран зохиолын олон ном монгол хэлнээ орчуулагдан хэвлэгдсэн юм. Нэг үгээр хэлбэл дайны жилүүдэд Монгол, Вьетнам хоёр улсын ах дүүгийн харилцаа бүх талаар бэхжсэнээс гадна Монгол, Вьетнамын ард түмэн бие биенээ гүн гүнзгий ойлгож, улам ойр дотно анд нөхөд болшгоосон юм.

1970-аад оны дунд үеэс дэлхий дахинд намжмал байдлын уур амьсгал давамгайлж, Энэтхэг-Хятадын хойгт дайны гал зогссон билээ. Олон жилийн дайны дараа хоёр Вьетнам нэгдэж Зүүн өмнөд Азид БНСВУ хэмээх нэгдмэл томоохон улс бий болсоныг та бүхэн мэднэ.

Энэ үед БНСВУ НҮБ-ын албан ёсны гишүүн болж мөн социалист орнуудын Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага/СЭВ/-д элсэн орж улс орноо сэргээн босгох ажлыг тууштай өрнүүлсэн юм.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай эдийн засаг, улс төрийн талаар улам ойртон нягтарч социализмын материал техникийн баазыг бэхжүүлэхийн төлөө идэвхийлж байсан Монгол улсын хувьд нэгдсэн Вьетнам улстай улс төр, эдийн засаг, соёлын харилцааг улам өргөн цар хүрээтэй хөгжүүлж таатай нөхцөл дайны дараах жилүүдэд бүрдсэн юм.

### **Өндөр дээд хэмжээний айлчлал /1975-1990 он/**

- 1978 онд БНСВУ-ын Гадаад харилцааны яамны орлогч сайд Хоан Лыонг тэргүүтэй төлөөлөгчид,  
1979 онд БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ж.Батмөнх тэргүүтэй нам засгийн төлөөлөгчид БНСВУ-д албан ёсны айлчлал хийв.  
1981 онд БНСВУ-ын ГХЯ-ны сайд Монголд айлчлав.  
1983 онд БНМАУ-ын АИХ-ын төлөөлөгчид Вьетнамд айлчлав.  
1984 онд БНСВУ-ын Төрийн зөвлөлийн дарга Чыонг Тинь тэргүүтэй нам төрийн төлөөлөгчид Монголд айлчлав.  
1985 онд БНМАУ-ын ГХЯ-ны сайд М.Дүгэрсүрэн Вьетнамд айлчлав.  
1987 онд БНСВУ-ын үндэсний хурлын төлөөлөгчид Монголд айлчлав

Энэ үед хоёр улсын хооронд өндөр дээд хэмжээний олон чухал айлчлал болсон юм. Эдгээр айлчлалын дүнд хоёр улсын харилцаанд чухал хэд хэдэн гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.

### **Гол гэрээ хэлэлцээр /1975-1990 он/**

- 1975 онд Бараа харилцан нийлүүлэх, төлбөрийн тухай хэлэлцээр /анхны удаан жилийн хэлэлцээр/
- 1977 онд Шуудан, цахилгаан холбооны талаархи Засгийн газар хоорондын хэлэлцээр
- 1977 онд Соёл, шинжлэх ухааны талаар хамтран ажиллах хэлэлцээр
- 1979 онд Найрамдал, хамтын ажиллагааны шинэчилсэн гэрээ

- 1979 онд Консулын конвенци
- 1979 онд Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комисс байгуулах тухай гэрээ

Үүнээс хамгийн чухал нь 1979 онд гарын үсэг зурсан Найрамдал хамтын ажиллагааны шинэчилсэн Гэрээ юм.

Энэ гэрээ нь 1961 оны гэрээг шинэ нөхцөл байдалд нийцүүлж, хамтын ажиллагааны агуулгыг үлэмж баяжуулан гүнзгийрүүлсэн гэрээ байлаа. Социалист нөхөрлөлийн орнуудын эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл /СЭВ/-ийн гишүүн болсон 2 орны хувьд хамтын ажиллагааг удаан жилийн төлөвлөгөөгөөр зохицуулж, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох, социалист нөхөрлөлийн орнуудын эв санааны нэгдлийг бэхжүүлэхэд хамтран тууштай тэмцэх зэрэг заалтыг тус гэрээнд онцлон заасан юм.

Дайны дараа БНСВУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг шударгаар шийдвэрлэхийн төлөө ах дүү социалист орнууд тууштай тэмцэж байв. БНСВУ-ыг НҮБ-д элсэхийг дэмжиж уг асуудлыг шударга зөв шийдэхийг хүссэн тогтоолын төслийг Аюулгүйн Зөвлөлд оруулсан зохиогчдын нэг нь Монгол Улс байсан юм.

Хэдийгээр 1975 онд Энэтхэг-Хятадын хойгт дайн төгсч Зүүн өмнөд Азид харьцангуй тайван цаг ирсэн ч гэсэн 1979 оноос Вьетнам, Хятадын харилцаанд хямрал гарч Зүүн өмнөд Азийн орнуудад олон жил үргэлжилсэн “Кампучийн асуудал” гэгч босч ирсэн билээ. Энэ асуудлаар Монгол, Вьетнам хоёр улсын байр суурь ижил байсан бөгөөд олон улсын тавцан дээр бие биенээ харилцан тууштай дэмжиж байлаа. Тухайлбал 1976 оноос 1990-ээд оныг хүртэл БНСВУ-ын Засгийн газар Зүүн өмнөд Азид энх тайван, тогтвортой байдлыг хангах үүднээс олон чухал санал санаачлага дэвшүүлснийг Монголын засгийн газар бүрэн дэмжиж зарим тохиолдолд НҮБ-ын индэр дээрээс байр сууриа илэрхийлж байв. /1986 оны 40-р чуулган/

Монгол улсын Засгийн газраас 1981 онд дэвшүүлсэн Ази, Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай конвенци, 1984 онд дэвшүүлсэн Улс түмэн, энх тайван орших тухай эрхийн тунхаглал зэргийг БНСВУ-ын Засгийн газар тууштай дэмжиж байв. Ер нь манай хоёр улс социалист нөхөрлөлийн орнуудын хамт НҮБ-ын хэлэлцэж буй гол гол асуудлаар ямагт санал нэг байсан.

Дайны дараах жилүүдэд хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа ЭЗХТЗ-ийн хүрээнд 5 жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байв. Үүний дүнд 1980-аад оны дунд үе хүртэл хоёр улсын худалдаа

2 дахин өсөв. Тухайлбал, 1976-1980 онд хоёр улсын бараа эргэлт 9,6 сая рубль байсан бол 1981-1985 онд 11,9 сая рубль болон өсчээ.<sup>7</sup>

Энэ үеийн худалдаа өмнөх 5 жилийнхээс 2 дахин өссөн боловч барааны нэр төрөл төдийлөн олширсонгүй, харин тоо хэмжээ нь нэмэгдсэн байна. Эдгээр онуудад Вьетнамаас төрөл бүрийн бэлэн хувцас, хиймэл торго, давсалсан самар, консерв, биеийн тамирын бараа, Монголоос хонины угаасан ноос, ноосон даавуу, аяны хөнжил, бугын ясан эвэр, ясны гурил, хаягдал хөнгөн цагаан нийлүүлж байсан байна.

Харин 1986-1990 оны урт хугацааны хэлэлцээрийн дагуу бараа солилцоог хэрэгжүүлэх эцсийн жил 1990 онд хоёр улсын гадаад худалдааны нийт хэмжээ дөнгөж 7,6 сая төгрөг болжээ. Энэ нь 1985 оныхтой харьцуулбал бараг 40-өөд хувиар буурсан үзүүлэлт юм. Үүний шалтгаан нь 1980-1990-ээд оны заагт манай хоёр оронд эдийн засгийн хямрал гүнзгийрч, мөн хуучин тогтолцоо эвдэрч шинэ тогтолцоо бүрэлдэж амжаагүй байсантай холбоотой байлаа.

1979 онд Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах Вьетнам, Монголын засгийн газар хоорондын комисс байгуулагдаж хамтын ажиллагааны чиглэл зорилгыг тодорхойлж жил жилээр төлөвлөх болсон нь 2 орны эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэхэд чухал нөхцөл бүрдүүлсэн байна.

Хоёр улсын худалдаа эдийн засгийн харилцаа урьд зөвхөн бараа солилцох, материаллаг тусламж үзүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байсан бол дайны дараа ялангуяа 1980-аад оноос эхлэн зарим нэг техник, технологи нийлүүлэх, барилга байгууламж барих, мэргэжилтэн солилцох гэх мэт шинэ агуулгаар баяжив. Жишээ нь Вьетнамын тал Монголд гар хивс, хиймэл цэцэг, ариун цэврийн цаасны үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлж, дүүжин гүүр, жижиг оврын усан цахилгаан станц барьж байгуулах боломжийг судлан, сүм хийд сэргээн засварлах зэрэгт мэргэжилтэн уран барилгачидаа илгээн ажиллуулах болов.

Хэдийгээр Вьетнамын дайн төгссөн ч гэсэн Монгол улсын зүгээс Вьетнамд туслах ажлаа зогсоосонгүй. 1980-аад оны сүүл хүртэл Монголын тусламж тодорхой хэмжээгээр үргэлжилсэн юм. Энэ нь Вьетнам улс олон жилийн дайнд нэрвэгдсэн, түүнийг сэргээн босгох их ажил өрнөж байсантай холбоотой.

Монголын Засгийн газар Вьетнамд 1976-1980 онд нийтдээ 13,6 сая орчим төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн байна. /1976 онд 4,0 сая төгрөг, 1978 онд усны үерт автсантай холбогдуулан 670,0 мянган төг, 1979 онд 6,2 сая төгрөг, 1980 онд 2,5 сая төг/<sup>8</sup>



Үүнээс гадна 1982-1985 онд Вьетнамд үзүүлэх буцалтгүй тусламжийн тухай хэлэлцээрийн дагуу Вьетнамд МАА-н салбарыг хөгжүүлэх зорилгоор урьд бэлэглэсэн 100,000 толгой малаас үлдсэн 85,000 толгой малын оронд гуравдагч орноос үржлийн үхэр худалдан авахад нь зориулж буцалтгүй тусламжийн хэлбэрээр 1,5 сая ам.долларыг Вьетнамын талд шилжүүлэн өгсөн байна. Үүний үр дүнд одоо БНСВУ-д Сүхбаатарын нэрэмжит томоохон үхрийн сангийн аж ахуй үр ашигтай ажиллаж байна.

Энэ үед Вьетнам нөхөд ч бас Монгол анд нөхдөдөө туслах гэсэн сэтгэл их байсан. Тухайлбал, 1978 онд Бангкок хотноо болсон Азийн орнуудын биеийн тамирын 8-р тоглолтод оролцох Монголын 40 орчим тамирчдыг Вьетнамын биеийн тамирын хороо хүлээн авч, Ханойд бэлтгэл хийх бүх бололцоог хангаж, тэнд байх зардлыг дааж байсан.

Хоёр улсын Засгийн газар хооронд 1977 онд гарын үсэг зурсан “Соёл шинжлэх ухааны хамтын ажиллагааны шинэ хэлэлцээр”-ийн дагуу соёл хүмүүнлэгийн салбарт /тухайлбал боловсрол, шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, хэвлэл мэдээлэл, спорт, эрүүлийг хамгаалах г.м/ хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлсэн байна.

Дайны дараах жилүүдэд Монголын Ардын дуу бүжгийн чуулга Вьетнамд 2 удаа, Вьетнамын урлагийн хэсэг Монголд мөн 2 удаа тус тус ирж тогложээ. Мөн хоёр улсын циркийн жүжигчид хэд хэдэн удаа харилцан айлчилж тоглосон байна.

Үүнээс гадна 1985 онд Вьетнамын соёлын өдрүүд Монголд болж, Монголын соёлын өдрүүд Вьетнамд 1987 онд тус тус зохион байгуулагдсан байна. Мөн зураач, сэтгүүлч, зохиолч, кино найруулагчид гэх мэт уран бүтээлчид болон эрдэмтдийг харилцан солилцох явдал олширсон байна.

Боловсролын салбарт оюутан солилцох ажил сэргэж эхлэв.

Эрүүлийг хамгаалах байгууллагуудын хооронд харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу эрдэм шинжилгээний мэдээлэл солилцох, эмч солилцох, ардын эмнэлгээр мэргэжил дээшлүүлэх, боловсон хүчнийг харилцан бэлтгэхэд анхаарал тавьж эхэлжээ.

Дайны дараах жилүүдэд Монгол, Вьетнамын харилцаа нийгмийн амьдралын бүх хүрээнд ийнхүү өргөжин тэлсэн юм. Энэ үед Монгол, Вьетнам хоёр улсын хоёр талын хамтын ажиллагааны цар хүрээ улам тэлснээс гадна социалист орнуудын Эдийн засгийн харилцан туслах зөвлөл, НҮБ, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож байжээ. Энэ үе бол хоёр улсын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагаа урьд урьдахаас илүү өргөн цар хүрээтэй хөгжсөн үе байлаа.

1990-ээд оноос хойш манай хоёр улсын хувьд шинэ зарчимд тулгуурласан, шинэ харилцааны үе эхэлсэн. Учир нь дэлхий дахинд өрнөсөн шинжлэх ухаан технологийн хувьсгалын үр дүнд хүн төрөлхтөний сэтгэлгээнд гүнзгий өөрчлөлт гарч, хоёр туйлт ертөнцийн хүйтэн дайны үе шувтрав. Дэлхийн дэг журам шинэ тогтолцоонд шилжиж улс гүрнүүдийн гадаад бодлого өөрчлөгдөв.

Манай орны гадаад бодлого ч шинэ нөхцөл байдлыг даган шинэчлэгдэж, харьцангуй бие даасан шинжийг олов. Монгол Улс үндэсний эрх ашгаа дээдэлсэн, бие даасан, тэнцвэртэй, олон тулгуурт, нээлттэй, идэвхитэй гадаад бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэв. Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болов.

Вьетнам улсын хувьд бие даасан олон чиглэл, олон хэлбэр бүхий нээлттэй гадаад бодлогыг хэрэгжүүлэх, энх тайван, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх орнуудтай нөхөрсөг, итгэлтэй түншийн харьцааг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж эхэлсэн юм. Үүнээс гадна уламжлалт харилцаатай орнуудтайгаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд БНСВУ байнга анхаарч ирэв.

Ийнхүү хоёр улсын гадаад бодлогын чиглэл зорилго адил төстэй олон шинж чанарыг агуулж байгаа нь цаашид харилцааг хөгжүүлэх ашиг сонирхол нэг байгааг харуулсан юм.

Юуны өмнө Монгол, Вьетнам 2 улсын харилцаанд үзэл суртал ангийн эрх ашгийг урьдал болгож, бодит байдлыг өөрөөр үнэлж байсан 40-өөд жилийн хэвшил шинэ нөхцөлд нэгэнт тохирохоо больсон тул харилцааны зарчмыг шинээр тодорхойлох мөн эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх хэрэгтэй болсон юм.

Эхний үед уламжлалт харилцааны туршлагыг залгамжлан хөгжүүлэхэд зохицсон арга хэлбэрийг олж чадахгүй цаг алдсан тал байвч 2 улсын харилцаа ялангуяа улс төрийн салбарт түргэн сэргэсэн билээ.

### **Өндөр, дээд түвшний айлчлал**

#### **/1990-ээд оноос өнөөг хүртэл/**

1994 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Вьетнамд айлчилсан.

1995 онд БНСВУ-ын Гадаад хэргийн сайд Монголд айлчлав.

1997 онд БНСВУ-ын Үндэсний хурлын орлогч дарга Данг Куан Тхюи тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

1998 онд УИХ-ын дарга Р.Гончигдорж тэргүүтэй төлөөлөгчид Вьетнамд айлчлав.

1999 онд БНСВУ-ын Ерөнхий сайд Монголд ажлын айлчлал хийв.

2000 онд БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дык Лёнг Монгол Улсад айлчлав.

2001 онд Монгол Улсын Гадаад хэргийн сайд Вьетнамд айлчлав.

2002 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид Вьетнамд айлчлав

2003 онд БНСВУ-ын Үндэсний хурлын дарга Нгуен Дань Ан тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

2004 онд МУИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид Вьетнамд айлчлав.

2004 онд БНСВУ-ын Ерөнхий сайд Фам Ван Кхай Монгол Улсад айлчлав.

1994 оноос өнөөг хүртэлх энэ богинохон хугацаанд хоёр улсын өндөр дээд хэмжээний айлчлал 10 гаруй удаа болж, 20 орчим Гэрээ хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурсан байна.

### **Гол гэрээ хэлэлцээрүүд:**

1995 онд Давхар татвараас зайлсхийх хэлэлцээр

1999 онд Иргэд харилцан зорчих нөхцлийн тухай хэлэлцээр

1999 онд Худалдааны хэлэлцээр

2000 онд Найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ /Анхны гэрээг 1961 онд байгуулсан, түүнийг 1979 онд шинэчилсэн, 2000 онд шинэ гэрээ байгуулсан/

2001 онд Соёлын салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр

2002 онд Ургамал хамгаалал, хорио цээрийн хэлэлцээр

2002 онд Гаалийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газрын хэлэлцээр

2004 онд Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр

2004 онд Шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр тус тус байгуулсан байна.

2000 онд Монгол Улс, БНСВУ-ын хооронд гарын үсэг зурсан Найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай шинэ Гэрээ нь хоёр орны шинэ зуунд чиглэсэн харилцааны үндсэн зарчим чиглэлийг тодорхойлсон тулгуур баримт бичиг болсон юм. Манай хоёр орны харилцаа хамтын ажиллагаа эдүгээ энэ шинэ гэрээний үзэл санааны дагуу хөгжиж байна.

## Монгол, Вьетнамын худалдаа эргэлт (1990-2003) (Мянган ам.доллар)

1991	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003***
6,7*	131,5	253,1	676,3	3052,0	1667,7	191,1**			1186,0	1219,0

Тайлбар: \*Үндэсний гаалийн газрын мэдээ  
\*\*\* 2000 оны 3-р сарын ГХЯ-ны лавлагаас  
\*\*\* БНСВУ-ын Статистик мэдээ, 2003 он

Хоёр орны худалдаа 80,90-ээд оны заагт бараг тасарч байснаа 90-ээд оны дунд үеэс сэргэж эхлэв. Тухайлбал хоёр орны худалдаа эргэлт 1990-1995 онд 400 гаруйхан мянган ам.доллар байсан бол 2000-2004 онд 5,1 сая орчим ам.доллар болжээ.

Вьетнамын зарим уламжлалт барааны оронд өргөн хэрэглээний шинэ бараа, эм тариа, үнэртэн, ариун цэврийн болон хүнсний бараа орж ирэх боллоо. Монголын зарим уламжлалт бараа Вьетнамын зах зээлээс шахагдаж Монголын экспорт бараг үгүй болов. Энэ нь манай барааны өрсөлдөх чадвар сул, зэс хавтан, ясны гурил, төрөл бүрийн бордоо, хуурай сүү, боловсруулсан арьс шир, савхи зэрэг Вьетнамд эрэлт хэрэгцээтэй барааны нөөц бага байгаатай холбоотой.

Сүүлийн жилүүдэд Вьетнамын 100%-ийн хөрөнгө оруулалттай болон хамтарсан хэд хэдэн компани Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ төдийлөн их биш байна. /200-300 сая төг/

Монгол Улс урьд өмнө Вьетнамд тусалдаг байсан бол Вьетнам улс эдүгээ Монголд тусламжийн гараа сунгах боллоо.

Вьетнам улс 1993 онд Монголын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зориулж 200,000 ам.доллар, ой хээрийн түймрийн хохирлыг арилгахад зориулж 15,000 ам.доллар, 2001 онд зудын гамшгийг гэтлэн давахад 2,000 тн цагаан будаа, 2004 онд УИХ-ын Судалгааны төвийг байгуулахад 10,000 ам.доллар, 2004 онд 300 компьютер, бусад хэрэгслийн хамт буцалтгүй тусламж болгон өгчээ.

1990-ээд оноос хоёр улсын боловсрол, соёлын харилцаа сэргэж эхлэв. Вьетнамын тал Монголын 10 гаруй боловсон хүчнийг урьд бэлтгэж өгсөн бөгөөд одоо Монголын 20-иод оюутан Вьетнамын их дээд сургуульд суралцаж байна. Монголд Вьетнамын 100 гаруй боловсон хүчин урьд бэлтгэсэн бөгөөд одоо Вьетнамаас жил бүр 2-3 оюутан хүлээн авч сургаж байна. Вьетнамын тал 2004 оноос эхлэн Монголоос жил бүр 20-40 хүртэл оюутан хүлээн авч сургаж өгөх боломжтой гэдгээ мэдэгдсэн байна.

Хоёр талд зохиогдож байгаа урлагийн наадам, биеийн тамирын зарим тэмцээнд хүмүүсээ харилцан оролцуулж, шинжлэх ухааны болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг солилцож байна. Гэвч соёл урлагийн байгууллагуудын төсөв зардал хязгаарлагдмал, мөн зах зээлийн горимд шилжсэнтэй холбоотойгоор соёл урлагийн харилцаа түргэн хөгжиж чадахгүй байна.

Хоёр талын худалдаа эдийн засгийн харилцааг бүх талаар хөгжүүлэхийн тулд Монгол, Вьетнамын төр, Засгийн газар үлэмжхэн чармайлт гаргаж байгаа боловч:

1. Хоёр орны үйлдвэрлэх хүчний хөгжил өндөр биш учраас экспортын барааны өрсөлдөх чадвар болон нөөц боломж хязгаарлагдмал

2. Бие биений зах зээлийг таньж мэдэх, нөөц бололцоог нээх талаар хоёр тал төдийлөн идэвхи гаргахгүй байгаа

3. Зам тээврийн хувьд хоорондоо хол байршилтай, тээврийн төлбөрийн тариф өндөр,

4. Төлбөр тооцооны таатай нөхцөл бүрдээгүй. Жишээ нь хоёр улсын төв банкны хооронд төлбөр тооцооны хэлэлцээр хийгдсэн боловч арилжааны банкуудын хооронд харилцаа төдийлөн байхгүй, худалдааны үйл ажиллагаанд үйлчлэх ажил хөшүүн хойрго, аккредитив нээх, хариуцлага хүлээх үйлчилгээний баталгаа сул зэрэг нэлээд бэрхшээлийг гэтлэн давж чадаагүй байна.

Бидний ойлгож байгаагаар хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд бага бус нөөц боломж бий. Түүнийг гүйцэд нээх хэрэгтэй байна.

Монгол, Вьетнам хоёр улс НҮБ, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, АСЕАН-ын АРФ зэрэг олон талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож ирлээ. Цаашид ч энэ чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлж олон улсын хэмжээнд харилцан бие биеэ дэмжих бодлого барьж байна.

Монгол Улс АПЕК-т элсэх АСД /Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ/ болон АСЕМ-ын үйл ажиллагаанд оролцох, АСЕАН-тай итгэмжит түншийн харьцаа тогтоон бэхжүүлэх эрмэлзлийг БНСВУ бүрэн дэмжиж ирлээ. Вьетнам улс НҮБ-д байнгын бус гишүүн болох, Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэх явдлыг Монгол Улс бүрэн дэмждэг юм.

## ДҮГНЭЛТ

Бид хоёр улсын харилцааны 50 жилийн түүхийг эргэн харахад:

1. Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд удаан хугацааны төлөвлөлтийг үндэслэж хамтын ажиллагаанд үлэмжхэн чармайлт гаргаж байсан боловч эдийн засгийн үр ашгийг тэр бүр нарийн тооцож байгаагүй тал бий. Мөн улс төрийн хамтын ажиллагаанд

үзэл суртал, ангийн эрх ашгийг урьтал болгож бодит байдлыг өөрөөр үнэлж байсан тал ч бий. Гэхдээ бидэнд харилцаа хамтын ажиллагааны баялаг өв уламжлал байна. Энэ өв уламжлал бол манай хоёр ард түмний хувьд эрхэм чухал үнэт зүйл мөн.

2. 50 жилийн хугацаанд хоёр ард түмний сэтгэлийг сэвтээсэн ямар нэг асуудал гараагүй. Харин ч ард түмнүүд бие биенээ гүнзгий ойлгож анд нөхдийн сэтгэлээр гагнагдсан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, энэ бол эмтэрч сэвтээгүй цэвэр ариунаараа байгаа харилцаа. Энэ утгаараа хоёр орны харилцаа цаашид өргөжин хөгжих бат бэх хөрс суурь бий гэж хэлэх үндэстэй.

3. Эдүгээ БНСВУ Зүүн Өмнөд Азийн холбоо /АСЕАН/-ы нэр нөлөө бүхий гишүүн орон, Монгол Улс АСЕАН-тай итгэмжит түншийн харилцааг тогтоон бэхжүүлэхийн төлөө чармайж байгаа энэ үед БНСВУ бол АСЕАН-ы орнуудтай харилцааг бэхжүүлэхэд гол түнш орон болох ёстой, болж ч байгаа.

4. Дэлхий даяар глобалчлал, интернационалчлал, бүсчлэлийн үйл явц өрнөж буй өнөө үед XXI зуун бол Азийн зуун болох нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байгаа бөгөөд АСЕАН хэмээх эдийн засгийн хөгжлийн шинэ төв Зүүн өмнөд Азид тодорч тэр нь удахгүй манай хил залгаа Зүүн Азийн орнуудтай нэгдсэн зах зээл бий болгох цаг ойртож байгаа өнөөгийн нөхцөлд Монгол, Вьетнамын харилцаа хэтийн асар их ирээдүй, нөөц бололцоог агуулж байна гэсэн цөөн хэдэн дүгнэлтийг давын өмнө хийж болмоор байна.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. ГХЯ-ны архив. Фонд №12, Х.Н. 35
2. Мөн тэнд
3. ЭТНБХ-ны архив /Гар бичмэл/
4. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны товч түүх. УБ. 2000 он, 130-р тал
5. БНМАУ-ын гадаад худалдааны хөгжил. УБ, 1981 он
6. БНСВУ-ын гадаад худалдаа сэтгүүл. 1987, №71
7. Ле Ван Зыонг “Вьетнам-Монголын харилцаа /1954-1990/ диссертаци зохиол. УБ, 1994, 102-р тал
8. Мөн тэнд. 100-р тал